



Өрхийн тариалангийн үр ашиг

Хашаандаа ногоо тариалахын ач холбогдол



- Та өөрийнхөө хашаандаа ажлын байр бий болгоно.
- Экологийн цэвэр орчинд ургуулсан төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг хүнсэндээ хэрэглэнэ.
- Таны хүүхдэд хөдөлмөрч, хамтач, тусч хүмүүжил төлөвшинө.
- Хөдөлгөөний дутагдал, баталгаагүй хүнс хэрэглэснээс үүсдэг төрөл бүрийн өвчлөлөөс сэргийлнэ.
- Хамгийн гайхалтай нь та өөрийн тарьсан ногоо, жимсийг хэрхэн ургаж байгааг харан, түүнийгээ усалж арчлах зэргээр өдөр тутмын амьдралын хэмнэлээ идэвхтэй болгох болно.
- Таны эргэн тойронд амьдарч байгаа айл өрхүүд танаас туршлага авч, орлогоо нэмэгдүүлж сурсанаар та тэдэнд амьдрах ухааны багш болж чадахаас гадна аж ахуй эрхэлж амжилтанд хүрэх эх сууриа тавина.

1 ам метр талбайн үр ашиг



Таримлын нэр	Үр			Ургац			Ашиг, төг
	Хэмжээ	Нэг бүрийн үнэ, төг	Бүгд үнэ, төг	Хэмжээ, кг	Нэг бүрийн үнэ, төг	Бүгд үнэ, төг	
Төмс	0.15- 0.2 кг	1000	1500- 2000	5	1000	5000	3000- 3500
Байцаа	3-4 ш үрслэг	300	900- 1200	8	1500	12000	10800- 11100
Шар лууван	0.006 гр	50000	300	4	2000	8000	7700
Шар манжин	0.002 гр	150000	300	4	2500	10000	9700
Сонгино	0.012 гр	60000	720	3	10000	30000	29280

5 ам бүлтэй айлын төмс, хүнсний ногооны жилийн хэрэгцээ

(Засгийн Газрын “Ногоон хувьсгал” үндэсний хөтөлбөрт зааснаар)



Төмс	250 кг
Байцаа	70 кг
Шар лууван	35 кг
Шар манжин	20 кг
Сонгино	25 кг
Бүгд	400 кг

Хэрэгцээт ногоог ургуулан авахад танд хэдэн м² талбай хэрэгтэй вэ?

Төмс	50-60
Байцаа	8-9
Шар лууван	9-10
Шар манжин	9-10
Сонгино	8-9

Бүгд 91

Та сайн ажиллаж чадвал ердөө 91 м² талбайгаас бүтэн жил хүнсэндээ хэрэглэх ногоогоо хураан авах боломжтой.



Дээрх ногоог ургуулан авахад танайх хашааныхаа талбайн хэдэн хувийг ашиглах боломжтой вэ?



❖ Хэрвээ танайх газрын шинэ хуулиар 700 м^2 хашааны талбай эзэмшдэг бол 14.3 %-иас нь

❖ Хэрвээ танайх газрын хуучин хуулиар 500 м^2 хашааны талбай эзэмшдэг бол 20 %-иас нь

Үрслэг ургуулбал илүү их ашигтай

- Бага талбайгаас олон үрслэг ургуулна.
- Бага зардлаар их ашиг олно.
- Үр худалдан авсан зардлаа богино хугацаанд 30-800 дахин өсгөх боломжтой



1 м² талбайгаас



Таримлын нэр	Үр			Гарах үрслэг			1 м ² талбайн ашиг	10 м ² талбайн ашиг
	Тоо хэмжээ, гр	Нэг бүрийн үнэ, төг, 1 кг буюу 1000 гр	Нийт үнэ, төг	Тоо хэмжээ, ш	Нэг бүрийн үнэ, төг	Нийт үнэ, төг		
Байцаа	3	250000	750	400	200	80000	79250	792500
Лооль	3	800000	2400	200	1500	300000	297600	2976000
Хэмх	10	800000	8000	200	1500	300000	292000	2920000
Цэцэг	5	100000	500	200	1500	300000	299500	2995000

Яг одоо хичээлийн дараа очоод таны хийх ажил

- Хашааныхаа сул зай талбайд хэмжилт хий.
- Танайд ногоо тариалах боломж байна уу сайн бод шийд.
- Сул талбайгаасаа хичнээн ургац авах боломж байгааг тооцоол.
- Жилийн хэрэгцээт хүнсний ногооныхоо хэдэн хувийг олох боломжтой байгааг тооцоол.
- Зах зээлд борлуулах илүү ургац авах боломж байгаа эсэхийг тооцоол.
- Илүү гарсан ургацаас олсон мөнгөө юунд зориулж зарцуулахаа гэр бүлээрээ хэлэлц.
- Ажлын төлөвлөлт хийж ахлагч томил.